



СОЁЛЫН ӨВ

БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Өмнийн Говийн бүс нутгийн соёлын өвийг хамгаалах, хадгалан үлдээх
- Монгол орны археологи, палеонтологийн соёлын өвийг хамгаалах, хадгалан үлдээхэд идэвхийлэн дэмжлэг үзүүлэх.

ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Уламжлал ёс заншил, амьжиргаа, үлгэр домог, хөгжим зэрэг соёлын өвд үзүүлэх нөлөөлөл
- Шинээр дэд бүтэц барьж байгуулахтай холбоотойгоор археологийн болон палеонтологийн олдворууд устах.

БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

ШИНЭ ЖИШГИЙГ БИЙ БОЛГОХ:

- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудад зориулан соёл, түүх, нийгмийн олдворуудыг хамгаалах чиглэлээр соёлын өвийг хамгаалах, хадгалан үлдээх шинэ жишгийг бий болгох
- Засгийн газрын зүгээс компанийн хариуцлагын стандартын шинэ загвар хэмээн тооцогдох хөтөлбөрийг хэрэгжүүлэх.





СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛСЭНЭЭР ДАРААХЬ ҮР ДҮНД ХҮРЭЭД БАЙНА. ҮҮНД:

- Өмнийн Говийн бүс нутгийн соёлын биет болон биет бус өвийг хадгалан үлдээх зорилго бүхий дэлхийн хэмжээний Соёлын өвийн хөтөлбөрийг эхлүүлсэн
- Хадгалан үлдээх, нөхөн сэргээх зорилгоо биелүүлэхэд чиглэсэн хамгаалалтын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлсэн
- Байгалийн болон хүний гараар бүтсэн бүс нутгийн соёлын өв бүхий газруудыг хамгаалах, каталогжуулахад зориулан 1.3 тэрбум төгрөг зарцуулсан
- Нутгийн ахмадуудын дурсамж, дуу хуурыг бичлэгээр хураан авч, хойч үед хадгалан өвлүүлэн үлдээх зорилго бүхий Аман хүүрнэл түүхийн хөтөлбөрийг эхлүүлсэн (хөтөлбөрт 100 гаруй ахмадууд хамрагдаад байна)
- Монголын мэргэжилтнүүдтэй хамтран олон тооны олдворуудыг нээн илрүүлсэн:
 - Үлэг гүрвэлийн 23 өндөг (олдворыг ШУТИС-д шилжүүлэн өгсөн)
 - Жавхлант багийн нутаг дахь шинээр олдсон хиргэсүүр (олдворыг ШУА-ийн Археологийн хүрээлэнд хүлээлгэн өгч, хамгаалалтад авсан)
 - Ханбогд суман дахь хадны бичээс (Үндэсний жагсаалтад бичигдсэн)
 - Зэс олборлолтын Хүрэл зэвсгийн үеийн багаж зэвсэг, Чулуун зэвсгийн үеийн багаж (ШУА-ийн Археологийн хүрээлэнд хүлээлгэн өгч, хамгаалалтад авсан).
- Сэргээн засварлалтын олон төрлийн үйл ажиллагааг явуулж дуусгаад байна:
 - Орон нутгийн музейд зориулан тухайн нутгийн ногоон чулуулгаар Оюу Толгой уулын загварыг бүтээлгэсэн
 - Говийн Догшин хутагт Данзанравжаагийн үндэслэн байгуулсан Галбын гурван хийдийн нэг Ханбогд суман дахь Дэмчигийн хийдийг сэргээн засварласан.

Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөлийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Соёлын өвийн менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г www.ot.mn цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.